

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 09 дүгээр
сарын 03-ны өдөр

Дугаар *28/2025*

Хэнтий аймаг

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 4.2, 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг тус тус үндэслэн Хэнтий аймгийн Засаг даргын **2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Комисс байгуулах тухай” А/630** дугаар захирамжаар байгуулагдсан 10 хүний бүрэлдэхүүнтэй Эрүүл мэндийн яамны захиалгатай, Хэнтий аймгийн Батноров сумын Бэрх хотод баригдсан Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, шинэчлэлтийн барилгын ажлыг ашиглалтад оруулах комисс **2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр** эрүүл мэндийн төвийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлын холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар:
- 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр, дугаар: **ХП-10/22**
- 2.3. Захиалагч: **Эрүүл мэндийн яам**, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: , регистрийн дугаар: 9087443 ; Хаяг: **Засгийн газрын VIII байр, Олимпын гудамж-2 Сүхбаатар дүүрэг 14210, Улаанбаатар хот Монгол улс**, холбоо барих утас: **11-323002** цахим шуудангийн хаяг: **letter@moh.gov.mn**;
- 2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: **“Өлке констракшн” ХХК**, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: **9011695001**, регистрийн дугаар: **6216862**, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: **БУ12-121/23**; Хаяг: **Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Улаанхуаран 64-66 тоот**, холбоо барих утас: **99222186, 88882187** цахим шуудангийн хаяг: **ulkeconstructionllc@gmail.com**;
- 2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага: **“Найрамдал оргил” ХХК** Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: **9011742090**, регистрийн дугаар: **6315763**, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: **БУ12-42/21**; Хаяг: **Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Улаанхуаран 64-66 тоот**, холбоо барих утас **99991065** цахим шуудангийн хаяг:

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: "Харш прожект" ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: **9011125033**, регистерийн дугаар: **2675633**, зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар **ЗТ19-496/2218**; Хаяг: **Улаанбаатар, Баянгол дүүрэг, 8-р хороо, 4-р хороолол, 7-1 тоот** холбоо барих утас: **99114877**;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Хэнтий аймгийн Батноров сумын Бэрх хотын **Эрүүл мэндийн төв** Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: **000277182** , регистрийн дугаар: **9074926**; Хаяг: **Хэнтий аймаг, Батноров сум, Бэрх хот**

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан.

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул;

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул;
- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул;

3.1. Энэхүү Эрүүл мэндийн яамны захиалгатай Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, шинэчлэлт Хэнтий, Батноров сум, Бэрх хот/-ын **ЭМЯ/20240101026/02/01** дугаартай ажил түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос **ДҮГНЭСЭН** нь:

Энэхүү барилгын шинэчлэл, тохижилтын ажил нь зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) Барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагуудад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

- а) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) Барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) Барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 3 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 13 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох иж бүрэн материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Эрүүл мэндийн яамны захиалгатай Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, шинэчлэлт Хэнтий, Батноров сум, Бэрх хот/-ын ЭМЯ/20240101026/02/01 дугаартай ажлыг үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан.

Комиссын дарга:


ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БХБХ-ИЙН
ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

Л.БААСАНХҮҮ

Комиссын нарийн бичгийн дарга:

“ӨЛКЕ КОНСТРАКШН” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

А.АХМАРАЛ



Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.